МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000. Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2020.03.27 № 1/684

танай 2020.02.19-ны № 03/525 -т

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД ОҮИТБС-ЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

Таны амгаланг айлтгая.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 26 дугаар тогтоолоор аймгийн нутаг дэвсгэрт олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд, нутгийн захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхэд хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах үүрэг бүхий ажлын хэсгийг 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж байна.

Тус зөвлөлийн орон нутаг дахь уул уурхайн салбарын ил тод байдлыг хангах чиглэлээр 2020 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хүргүүлэв.

Хавсралт: 3 хуудастай

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ш.ЁЛ

010620201

БАТЛАВ:
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ,
ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.ЁЛ

ЖЮА0005

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Чойбалсан хот

| Зорилтууд | Төлөвлөсөн ажлууд | Үр дүн | Хариуцах байгууллага | Хугацаа | Төсөв |
|---|---|---|---|---|---|
| 1. Орон нутаг дахь тусгай зөвшөөрлийн ил тод байдлыг хангах | Ашигт малтмал газрын тосны газрын кадастарын системд бүртгэлтэй Дорнод аймагт үйл ажиллагаа явуулах эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн дэлгэрэнгүй судалгааг авах хүсэлт хүргүүлэх | Баталгаат судалгаанд үндэслэн мэдээллийн сан бүрдүүлэх боломж бүрдэнэ | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс | 3-4-р сар | Зохион байгуулалтын |
| | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг сар бүр албан ёсны цахим хуудсаар дамжуулан авч байх. | Баталгаат мэдээллээр хангагдана. | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс | 3-4-р сар | Зохион байгуулалтын |
| | Аймгийн уул уурхайн цахим хаягт аж ахуйн нэгжүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг бүрэн байршуулах | Аж ахуйн нэгж бүрийн онцлог, тооцоо судалгаа тодорхой болсон байна. | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс | 5-10-р сар | Зохион байгуулалтын |
| 2. Орон нутаг, тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын харилцааг сайжруулах, байгаль орчныг хамгаалахаар байгуулсан гэрээний | Газрын тосны салбарын уулзалтыг Чойбалсан хотод зохион байгуулах | Тулгамдаж байгаа асуудлууд шийдвэрлэгдэнэ | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс Дэд зөвлөл | 5-6-р сар | 3 сая төгрөг |
| | Уул уурхайн салбарын зөвлөгөөнийг Чойбалсан хотод зохион байгуулах | Орон нутаг, аж ахуйн нэгж хоорондын харилцаа сайжирна. | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс, Дэд зөвлөл | 5-6-р сар | 5 сая төгрөг |
| | Салбарын хууль тогтоомж, стандартыг мөрдөн ажиллаж, хариуцлагатай уул | Олон нийт хариуцлагатай уул | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс | 5-12-р сар | Зохион байгуулалтын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| хэрэгжилтэд хяналт тавих | уурхайг хөгжүүлэн ажиллаж байгаа аж ахуйн нэгжийг олон нийтэд сурталчилан үйл ажиллагааг дэмжих | уурхайн салбарын хөгжлийг дэмжинэ. | Дэд зөвлөл | | |
| | Ашигт малтмалын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг дүгнэн хэлэлцүүлж, олон нийтэд сурталчилах, www.iltodgeree.mn-д бүх сумдын байгуулсан гэрээ орсон эсэхийг шалгах, нөхөн оруулах; | Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлсэн дэмжлэг тодорхой болно. | АЗДТГ-ийн ХОХБТ- ийн Хэлтэс, Дэд зөвлөл | 3-12-р сар | Зохион байгуулалтын |
| | Уул уурхай, газрын тосны тээвэрлэлтийг хатуу хучилттай авто замаар тээвэрлэхгүй байгаа аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг Монгол Улсын Засгийн газар холбогдох яамдад уламжлан хүргүүлэх | Холбогдох яамдад хүсэлт хүргүүлсэн байна. | Дэд зөвлөл, аймгийн ҮЭ хороо | 3-12-р сар | Зохион байгуулалтын |
| | Ашигт малтмал ашигласны дараа байгаль, экологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийсэн эсэхэд хяналт тавьж ажиллах | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс БОАЖГ Дэд зөвлөл, | 3-12-р сар | Зохион байгуулалтын |
| | “Ослыг тэглэе” аяны хүрээнд уул уурхай эрхлэгч аж ахуй нэгжүүдэд аймгийн ХАБЭА-н зөвлөлийн даргын нэрэмжит үзлэг хийх | Хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Дэд зөвлөл, Аймгийн ҮЭ хороо | 3-12-р сар | Зохион байгуулалтын |
| 3. Дэд зөвлөлийн гишүүдийн мэдлэг, мэдээлэл солилцох боломжийг бий болгох, үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хэрэгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөгөөн, цуврал сургалтуудад идэвхитэй хамрагдах, | Уул уурхайн салбарын шинэ, мэдээ мэдээллээр хангагдсан байна. | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс Дэд зөвлөл, | 3-12 сар | Зохион байгуулалтын |
| | Уул уурхай бүхий сумдад дэд зөвлөлийг байгуулах | Уул уурхайн үйл ажиллаанд тавих хяналт сайжирсан байна. | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс, Дэд зөвлөл | 3-4-р сар | Зохион байгуулалтын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Уул уурхай бүхий сумдад “Уул уурхайн амьдралын мөчлөг” сургалтыг зохион байгуулах | Уул уурхайн төслийн талаар иргэдийн ойлголт сайжирсан байна. | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс, Дэд зөвлөл | 5-9-р сар | Зохион байгуулалтын |
| | Сумдаас холбогдох мэдээлэл, 2019 оны ОҮИТБС-ын тайланг хүлээн авч, нэгтгэн цахимаар гаргах | Олборлох салбараас хүлээн авсан аймгийн орлого ил тод болж, мэдээллээр хангагдсан байна. | Аймгийн татвар, төрийн сан | 4-р сарын 15 | Зохион байгуулалтын |
| | Хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, заавар, чиглэл өгөх | Хуулийн зөрчил буурсан байна | АЗДТГ-ийн ХОХБТХэлтэс, Дэд зөвлөл | 6-9 сар | Зохион байгуулалтын |

ХЯНАСАН:

ХОХБТХ-ИЙН ДАРГА Х.БАТ-ЭРДЭНЭ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

ХОХБТХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН У.УРАНБИЛЭГ

ЖЮА-007 9029346